Octagon
CONNECTING SUCCESSES

“ПОВЕРЭД ЭЙ ДИ ЭМ” ХХК

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч ОКТАГОН крипто биржийн 2025 оны үйл ажиллагааны тайлан

АГУУЛГА

1. ОРШИЛ
2. САНХҮҮ
   - 2.1. Тайлант жилд ВХҮҮ-ийн орлогод нөлөөлсөн хүчин зүйл
   - 2.2. Гадаад дотоод эх үүсвэрээс санхүүжилт татах боломж
3. БҮТЭЭГДЭХҮҮН
   - 3.1. Бүтээгдэхүүн үйлчилгээний шинэчлэлт, төрөлжилт, өөрчлөлт
   - 3.2. Хадгалж, удирдаж байгаа харилцагчийн виртуал болон мөнгөн хөрөнгийн тоон үзүүлэлт
4. ПРОГРАММ ХАНГАМЖ
   - 4.1. Программ хангамж, систем
   - 4.2. Технологийн дэд бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа
   - 4.3. Биржийн нууцлал
   - 4.4. Аюулгүй байдалд хийлгэсэн эрсдэлийн үнэлгээний дүгнэлт
   - 4.5. Эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ
5. ЭРСДЭЛ
   - 5.1. Сонирхлын зөрчилтэй хэлцэлд оролцогч тал
   - 5.2. Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт
   - 5.3. Дотоод аудитын ажлын тайлан
6. ДҮГНЭЛТ

1. ОРШИЛ

“Поверэд Эй Ди Эм” ХХК нь 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрхээ авсан.

“Поверэд Эй Ди Эм” ХХК-ийн хувьцааны 50 хувийг “Поверэд” ХХК, 50 хувийг “Алтан Дорнод Монгол” ХХК тус тус эзэмшдэг. “Поверэд Эй Ди Эм” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь нийт 7 гишүүнтэй бөгөөд үүнээс хараат гишүүн 4, хараат бус 3 гишүүн болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Төгөлдөр, гишүүнээр Н.Батбаяр, Т.Ганболд болон Ж.Дэлгэрсайхан нар томилогдсон. Харин Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр А.Энхбаяр, С.Өнөржаргал болон Ж.Хүнболд нар тус тус томилогдсон болно.

СЗХ-ны 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 657 тоот тогтоолоор батлагдсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-ын 3.15-д заасны дагуу дараах агуулгын хүрээнд тайлангаа бэлтгэсэн болно. Үүнд:

1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн орлогод нөлөөлсөн хүчин зүйлс
2. Санхүүгийн нөөцөөр бизнесийн үйл ажиллагаанаас бий болсон өр төлбөрийг бүрэн хариуцах болон шаардлагатай тохиолдолд гадаад, дотоод эх үүсвэрээс санхүүжилт татах боломжтой эсэх
3. Бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэчлэл, төрөлжилт, өөрчлөлт
4. Хадгалж, удирдаж байгаа харилцагчийн виртуал болон мөнгөн хөрөнгийн тоон үзүүлэлт
5. Ашиглаж буй программ хангамж, систем, мэдээлэл, технологийн дэд бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдалд хийлгэсэн эрсдэлийн үнэлгээний дүгнэлт, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ
6. Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл, тухайн хэлцэлд оролцогч талууд
7. Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт, дотоод аудитын ажлын тайлан
8. Бусад мэдээлэл

2. САНХҮҮ

2025 оны байдлаар олон улсын криптовалютын зах зээл 2024 оны хүчтэй өсөлтийн дараах засварын шатанд шилжиж, Биткойн болон голлох криптовалютуудын үнэ харьцангуй тогтворжсон боловч идэвх сул хэвээр байна. Өмнөх онд Биткойн шинэ дээд түвшинд хүрч зах зээлд эерэг хүлээлт бий болгосон ч 2025 онд дэлхийн макро эдийн засгийн нөхцөл, ялангуяа өндөр хүүгийн бодлого, хөрөнгө оруулагчдын эрсдэлээс зайлсхийх хандлага болон криптовалютын зохицуулалтын тодорхойгүй байдал зэргээс шалтгаалан зах зээлд шинэ хөрөнгө оруулалтын урсгал буурсан байна. Үүний нөлөөгөөр крипто зах зээлд арилжааны идэвх буурч, үнийн хэлбэлзэл харьцангуй тогтворжсон нь зах зээлийг шилжилтийн буюу “accumulation” үе шатанд байгааг илтгэж байна.

Монгол Улсын хувьд крипто зах зээлийн идэвх олон улсын зах зээлийн чиг хандлагатай уялдсан хэвээр боловч дотоодын онцлог хүчин зүйлсээс шалтгаалан сэргэлт удаашралтай байна. Тухайлбал, Монгол банкны комплайнс бодлогоос үүдэлтэй гүйлгээний хязгаарлалт, хууль эрх зүйн орчны тодорхойгүй байдал, мөн өмнөх жилүүдийн зах зээлийн уналтаас үүдэн хэрэглэгчдийн итгэл буурсан зэрэг нь дотоодын биржүүдийн арилжааны хэмжээнд шууд нөлөөлж байна. Үүний улмаас хэрэглэгчид олон улсын платформыг илүүд үзэх хандлага хэвээр байгаа бөгөөд дотоодын зах зээлд хөрвөх чадвар, идэвх сул хэвээр байна. Иймд одоогийн нөхцөл байдлыг уналт гэхээс илүүтэйгээр зах зээлийн дараагийн өсөлтийн мөчлөгийн өмнөх бэлтгэл үе шат гэж үзэх боломжтой бөгөөд энэ хугацаанд дотоодын биржүүд технологи, бүтээгдэхүүн, стратегийн түншлэлд төвлөрөх шаардлага өндөр байна.

(Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.15.2 дахь хэсэгт зааснаар санхүүгийн нөөцөөр бизнесийн үйл ажиллагаанаас бий болсон өр төлбөрийг бүрэн хариуцах болон шаардлагатай тохиолдолд гадаад, дотоод эх үүсвэрээс санхүүжилт татах боломжтой эсэхийн хүрээнд дараах мэдээллийг оруулсан болно)

2.1 ВХҮҮ-ИЙН ОРЛОГОД НӨЛӨӨЛСӨН ХҮЧИН ЗҮЙЛС

Октагон крипто биржийн орлогод 2025 онд дараах үндсэн хүчин зүйлс нөлөөлсөн болно. Үүнд:

2.1.1 Хууль, зохицуулалтын тодорхойгүй байдал

Сүүлийн жилүүдэд криптовалютын хэрэглээ, зах зээлийн оролцоо нэмэгдэж байгаатай холбоотойгоор төр, зохицуулагч байгууллагуудын зүгээс энэхүү салбарыг зохицуулах эрх зүйн орчныг үе шаттайгаар бүрдүүлэх чиглэлд тодорхой ахиц гарч байна. 2025 оны байдлаар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй холбоотой журам, шаардлагууд тодорхой хэмжээнд боловсронгуй болж байгаа боловч салбарын урт хугацааны тогтвортой, нэгдсэн бодлого бүрэн төлөвшөөгүй хэвээр байна.

Энэхүү шилжилтийн үе шатад хууль, зохицуулалтын орчны өөрчлөлт, шинэчлэлтүүд нь зах зээлд оролцогчдод тодорхой түвшний тодорхой бус байдал үүсгэж, хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалтад сөргөөр нөлөөлөх хандлагатай байна. Түүнчлэн татварын асуудал, комплайнс, хяналт шалгалтын шаардлагууд нэмэгдэж буй нь зах зээлийн ил тод байдал, хариуцлагыг сайжруулах эерэг талтай боловч богино хугацаанд бизнесийн үйл ажиллагааны зардал болон эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна.

2.1.2 Банкны комплайнс бодлого

Монгол банк, санхүүгийн байгууллагуудын комплайнс бодлого нь криптовалюттай холбоотой гүйлгээнд болгоомжтой хандах чиг хандлагатай хэвээр байгаа нь дотоодын крипто биржүүдийн үйл ажиллагаанд тодорхой хэмжээнд нөлөөлж байна. Ялангуяа зарим банкны зүгээс крипто арилжаатай холбоотой гүйлгээнд хязгаарлалт тавих эсвэл өндөр хяналт шаарддаг нь хэрэглэгчдийн хөрөнгө оруулалтын урсгалыг сааруулах нөхцөл бүрдүүлж байна.

Үүний үр дүнд хэрэглэгчид олон улсын крипто платформууд (Binance, OKX, Bybit гэх мэт)-ыг ашиглах, P2P хэлбэрийн арилжаа хийх хандлага тодорхой түвшинд хадгалагдсан хэвээр байна. Энэ нөхцөл байдал нь дотоодын зах зээлийн хөрвөх чадвар, арилжааны хэмжээнд нөлөөлж байгаа бөгөөд цаашид банк, финтек болон крипто салбарын

уялдаа холбоог сайжруулах, төлбөрийн илүү үр ашигтай шийдлүүдийг хөгжүүлэх шаардлага байгааг харуулж байна.

2.1.3 ОУ-ын зах зээлийн нөлөө

Олон улсын криптовалютын зах зээлийн нөхцөл байдал нь Монгол Улсын дотоодын зах зээлд шууд болон шууд бус байдлаар нөлөөлсөөр байна. 2025 оны хувьд крипто зах зээл 2024 оны өсөлтийн дараах засварын үе шатанд шилжиж, голлох криптовалютуудын үнэ харьцангуй тогтворжсон боловч арилжааны идэвх буурсан нь нийт зах зээлийн хөрвөх чадварт нөлөөлсөн.

Энэ нь олон улсын хөрөнгө оруулагчдын эрсдэлийн үнэлгээ, макро эдийн засгийн нөхцөл байдал, мөн институционал хөрөнгө оруулалтын урсгалтай холбоотойгоор зах зээлийн идэвхжил саарахад хүргэсэн бөгөөд Монголын хэрэглэгчид мөн адил энэхүү чиг хандлагыг даган арилжааны идэвхээ бууруулах хандлага ажиглагдсан.

Нөгөө талаас, олон улсын зах зээл тогтворжих, институционал оролцоо нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа нь дунд болон урт хугацаанд зах зээлийн өсөлтийн суурь нөхцөл бүрдэж байгааг илтгэж байна. Гэсэн хэдий ч дотоодын зах зээлийн хувьд хэрэглэгчдийн итгэл, хөрвөх чадвар, дэд бүтцийн хөгжил зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан олон улсын өсөлтийн нөлөө шууд, хурдтай дамжихгүй хэвээр байна.

2.2 ГАДААД, ДОТООД ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИЛТ ТАТАХ БОЛОМЖ

Манай байгууллага 2025 онд санхүүгийн нөөцийн удирдлагыг сайжруулах, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд дотоод эх үүсвэрт тулгуурласан санхүүжилтийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. Тайлант хугацаанд үйл ажиллагаанаас бий болсон орлого, мөнгөн урсгалыг оновчтой удирдах замаар богино хугацааны өр төлбөрийг хэвийн гүйцэтгэж, санхүүгийн сахилга бат, төлбөрийн чадварыг ханган ажилласан болно. Санхүүгийн эрсдэлийг бууруулах, хөрвөх чадварыг хадгалах зорилгоор зардлын хяналт, үр ашигт ажиллагааг сайжруулах чиглэлээр шат дараатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

Мөн байгууллагын дунд болон урт хугацааны өсөлтийг дэмжих хүрээнд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын боломжуудыг

идэвхтэй судалж, стратегийн түншлэл, технологийн хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлд тодорхой ажлуудыг хэрэгжүүлсэн. Крипто зах зээлийн идэвх харьцангуй сул байгаа нөхцөлд бид бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, технологийн чадавхыг бэхжүүлэх, олон улсын зах зээлтэй холбогдох дэд бүтцийг сайжруулахад төвлөрсөн. Эдгээр арга хэмжээ нь цаашид хөрөнгө оруулалт татах суурь нөхцөлийг бүрдүүлэх, байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байна.

3. БҮТЭЭГДЭХҮҮН

Октагон бирж нь хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцсэн олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэн нэвтрүүлж, крипто арилжааны экосистемийг өргөжүүлж байна. Манай бүтээгдэхүүнүүд нь хөрөнгө оруулагчдад илүү ашигтай, аюулгүй, хүртээмжтэй шийдлүүдийг санал болгож, дижитал санхүүгийн боломжийг өргөжүүлэхэд чиглэгддэг.

(Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.15.3 дах хэсэгт зааснаар Октагон крипто биржийн бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэчлэл, төрөлжилт, өөрчлөлтийн хүрээнд дараах мэдээллийг боловсруулж бэлдсэн болно.)

3.1 Октагон крипто биржийн бүтээгдэхүүн үйлчилгээний шинэчлэл, өөрчлөлт, төрөлжилт

Октагон крипто бирж нь 2025 онд бүтээгдэхүүн, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагааны тогтвортой байдлыг хадгалах, технологийн дэд бүтцийг бэхжүүлэхэд төвлөрөн ажилласан. Тайлант хугацаанд бирж нь үндсэн арилжаа ADMC токен дээр төвлөрүүлэн явуулж, системийн найдвартай ажиллагаа, аюулгүй байдлыг хангах чиглэлд тасралтгүй сайжруулалт хийсэн. Үүний зэрэгцээ Bitcoin, Ethereum, BSC зэрэг олон улсын сүлжээнүүдийг дэмжих техникийн боломжийг бүрдүүлж, цаашид бүтээгдэхүүний төрөлжилтийг өргөжүүлэх суурь нөхцөлийг хадгалж ажилласан.

2025 оны байдлаар олон улсын криптовалютын зах зээл нь спекуляци давамгайлсан үе шатнаас бодит хэрэглээнд суурилсан хөгжлийн шат руу шилжиж, Блокчэйн технологид суурилсан санхүүгийн шийдлүүд (крипто төлбөр, DeFi, токенжуулалт гэх мэт)

илүү тогтвортой, практик хэрэглээтэй болж байна. Энэхүү чиг хандлагад нийцүүлэн Октагон бирж нь өөрийн технологийн дэд бүтцийг сайжруулах, хэрэглэгчдэд илүү найдвартай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэхэд анхаарч ажилласан.

Түүнчлэн, бирж нь олон улсын крипто платформуудтай интеграц хийх зорилгоор API хөгжүүлэлтийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, арилжааны дэд бүтцээ өргөжүүлсэн. Ингэснээр хэрэглэгчид олон улсын зах зээлийн ликвидитид холбогдох боломжийг уе шаттайгаар бүрдүүлж, цаашид арилжааны боломжийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдэж байна. Мөн хэрэглэгчийн танин баталгаажуулалтын (KYC) технологийг сайжруулж, олон улсын стандартад нийцүүлэх чиглэлд хөгжүүлэлт хийснээр хэрэглэгчийн бүртгэл, аюулгүй байдлыг нэмэгдүүлэхэд анхаарсан. Эдгээр шинэчлэлүүд нь Октагон биржийн технологийн чадавхыг бэхжүүлж, ирээдүйд бүтээгдэхүүн үйлчилгээний төрөлжилтийг нэмэгдүүлэх, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулах суурь болж байна.

3.2 Хадгалж, удирдаж байгаа харилцагчийн виртуал болон мөнгөн хөрөнгийн тоон үзүүлэлт

(Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.15.4 дэх хэсэгт зааснаар Октагон крипто биржийн хадгалж, удирдаж байгаа харилцагчийн виртуал болон мөнгөн хөрөнгийн тоон үзүүлэлтийн хүрээнд бэлдсэн болно)

Октагон бирж дээр 2026 оны 3 сарын 23-ний байдлаар нийт 16,925 харилцагч бүртгэлтэй байгаагаас ДАН-гаар баталгаажуулалт хийсэн 2,341 хэрэглэгч байна.

Тэдгээрийг насны хувьд ангилж авч үзвэл

- 16-30 насны 774 хэрэглэгч,
- 30-45 насны 1,272 хэрэглэгч,
- 45 болон түүнээс дээш 295 хэрэглэгч байна.

Мөн хүйсээр ангилж үзвэл

- 1,725 эрэгтэй хэрэглэгч,
- 616 эмэгтэй хэрэглэгчтэй байна.

Идэвхтэй буюу “Stake”-нд байгаа хадгалсан нийт 0 хэрэглэгчийн 0 ADMC байна.

Нийт хэрэглэгчийн хэтэвчний үлдэгдэл:

- 1,838 хэрэглэгчийн 8,302,281,240 ADMC
- 930 хэрэглэгчийн 265,493,450 MNT

4. ПРОГРАММ ХАНГАМЖ

Октагон крипто бирж нь 2025 онд программ хангамж, технологийн дэд бүтцийн найдвартай байдал, аюулгүй ажиллагаа, тасралтгүй үйл ажиллагааг хангах чиглэлд хөгжүүлэлт, сайжруулалт тогтмол хийж ажилласан. Бид системээ Блокчэйн технологид суурилсан орчин үеийн шийдлүүдийг ашиглан хөгжүүлсэн бөгөөд олон улсын түвшний аюулгүй байдал, гүйцэтгэл, өргөтгөх боломжийг хангах архитектур дээр ажиллаж байна.

Тайлант хугацаанд системийн гүйцэтгэл, арилжааны хурд, хэрэглэгчийн туршлагыг сайжруулах зорилгоор дэд бүтцийн оновчлол, API холболтын хөгжүүлэлтүүдийг үргэлжлүүлэн хийж, олон улсын крипто платформуудтай интеграц хийх техник боломжийг бэхжүүлсэн. Үүний зэрэгцээ системийн тасралтгүй ажиллагааг хангах, өгөгдлийн найдвартай хадгалалт, хамгаалалтыг сайжруулах чиглэлээр серверийн орчин, сүлжээний хамгаалалт, хяналтын механизмуудыг тогтмол сайжруулж ажилласан.

Мөн хэрэглэгчийн танин баталгаажуулалтын (KYC) системийг олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, хамгаалалтыг хангах, санхүүгийн гэмт хэрэг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжийг нэмэгдүүлсэн. Энэ систем нь хэрэглэгчийн бүртгэл, баталгаажуулалтын үйл явцыг илүү найдвартай, ил тод болгох үндсэн дээд бүтэц болж, биржийн нийт үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

(Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.15.5 дах хэсэгт зааснаар Ашиглаж буй программ хангамж, систем, мэдээлэл, технологийн дэд бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдалд хийлгэсэн эрсдэлийн үнэлгээний дүгнэлт, эрсдэлийг бууруулах,

урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд дараах байдлаар тайлбарласан болно)

4.1 Октагон крипто бирж дээр ашиглаж буй программ хангамж

“Поверэд Эй Ди Эм” ХХК нь Виртуал хөрөнгийн үйлчилгээнд Front-end flutter, Back-end Node.js болон Server Aws гэсэн программуудыг ашиглаж байгаа болно.

“Front-end flutter” нь Google-ээс өөрийн гар утасны аппликэйшн үүсгэхэд зориулсан үнэ төлбөргүй, нээлттэй загвар бүхий UI “Front-end” технологи юм. 2017 онд гарсан “Flutter” нь хөгжүүлэгчдэд нэг кодын сан болон программчлалын хэлээр гар утасны программ бүтээх боломжийг олгосон. Энэ чадвар нь IOS болон Android программуудыг аль алиныг нь хялбар, хурдан бүтээх боломжийг олгодгоороо давуу талтай учраас манай байгууллага ашигладаг.

“Back-end Node.js” нь JavaScript Engine (Жишээлбэл, V8 хөдөлгүүр) дээр ажилладаг, өргөтгөх боломжтой сүлжээний программуудыг бүтээхэд зориулсан веб хөтчөөс гадуур JavaScript кодыг ажиллуулдаг нээлттэй эх сурвалжтай, cross платформтой, back-end JavaScript ажиллах орчин юм. Node.js нь хэрэглэгч веб хөтөч рүү хуудсыг илгээхээс өмнө динамик веб хуудас агуулгыг бий болгохын тулд сервер талын скриптүүд болон сервер талын скриптүүдийг бичихэд JavaScript ашиглах боломжийг хөгжүүлэгчид олгоно. Иймээс “Node.js” нь сервер болон клиент талын скриптүүдийн өөр хэлээр бус, программчлалын нэг хэлний эргэн тойронд веб программ хөгжүүлэлтийг нэгтгэсэн "JavaScript хаа сайгүй" парадигмыг төлөөлж чаддагаараа давуу талтай.

“Server Aws нь Amazon Web Services” (AWS) нь дэлхийн хамгийн өргөн цар хүрээтэй, түгээмэл ашигладаг үүлэн платформ бөгөөд дэлхий нийтийн хэмжээнд дата төвүүдээс 200 гаруй бүрэн боломжит үйлчилгээг санал болгодог. Хамгийн хурдацтай хөгжиж буй стартап, томоохон аж ахуйн нэгж, төрийн байгууллагууд зэрэг олон сая үйлчлүүлэгч зардлаа бууруулж, илүү уян хатан байдлаар илүү хурдан инновац бүтээх зорилгоор AWS-ийг ашиглаж байна.

4.2 Октагон бирж дээр ашиглаж буй технологийн дэд бүтэц, түүний тасралтгүй найдвартай ажиллагаа

Октагон биржийн технологийн дэд бүтэц нь дараах 5 хэсгээс бүрдэнэ. Үүнд:


1. Route 53 DNS
2. AWS VPC (private network zone)
    a. AWS RDS multi Zone
    b. Elastic Load balancer
    c. Hashicorp vauit
3. Elastic Kubernetes service
4. Fireblocks
5. Бусад

Эдгээр дэд бүтцийг тус бүрд нь авч үзвэл:

Route 53 DNS

“Amazon Route 53” бол өндөр хүртээмжтэй, өргөтгөх боломжтой “Домэйн Нэрийн Систем” (DNS) веб үйлчилгээ юм. Энэхүү үйлчилгээ нь хэрэглэгчийн хүсэлтийг AWS эсвэл суурин ажиллаж байгаа интернэт программуудтай холбодог.

Загварчилгаа 1. Route 53 DNS



Эх сурвалж: BXYY, Поверэд Эй Ди Эм


AWS VPC (private network zone)

Октагон крипто бирж нь дараах системийн тусламжтайгаар AWS дээр 24/7/365 ажилладаг. Үүнд:

a. AWS RDS multi Zone

Amazon RDS Multi-AZ-д байршуулахдаа Amazon RDS нь үндсэн мэдээллийн сан (DB)-г автоматаар үүсгэж, өгөгдлийг өөр AZ дахь жишээнд синхроноор хуулбарладаг. Системд алдаа гарсан тохиолдолд Amazon RDS нь гар ажиллагаагүйгээр автоматаар зогсох горимд шилжинэ.

Загварчилгаа-2. AWS RDS Multi Zone



b. Elastic Load balancer

Ачааллыг тэнцвэржүүлэгч (ELB) нь нэг буюу хэд хэдэн боломжит бүсэд (AZs) зорилтот болон виртуал олон хэрэгслээр ирж буй программын траффикыг автоматаар хуваарилдаг.

Загварчилгаа-3. Elastic load balancer




c. Hashicorp vault

"HashiCorp Vault" нь байгууллагуудын мэдээлэлд суурилсан аюулгүй байдлын автоматжуулалт, үйлчилгээ болгон шифрлэлтийн мусламжтайгаар зөрчил, мэдээлэлд өртөх эрсдэлийг бууруулахад тусалдаг.

Elastic Kubernetes service

Amazon Elastic Kubernetes Service (Amazon EKS) нь Kubernetes программуудыг үүлэн сервер эсвэл газар дээр нь ажиллуулах масштабжуулах зориулалттай удирддаг агуулах үйлчилгээ юм.

График 1. Elastic Kubernetes service



Fireblocks

Манай байгууллагын хувьд Fireblocks-оос дараах үйлчилгээг авч байна. Үүнд:

1. Ашиглалт үйлчилгээний гэрээтэй Блокчэйн node,

2. Даатгал, ашиглалт үйлчилгээний гэрээ бүхий крипто хэтэвч,

3. Криптой гүйлгээний дүрмүүд тохируулж мэдэгдэл авах, нэмэлт баталгаажуулалт авах боломж.

Манай байгууллагын хувьд *Chainalysis*-аас KYT үйлчилгээг авч байна.

KYT - Know your customer буюу бүх гүйлгээг шалгаж илгээгч болон хүлээн авагч хэтэвч нь хар жагсаалтад орсон эсэх, тодорхой давтамжтай илгээж сэжигтэй үйлдэл хийж байгаа, мөнгө угааж буй эрсдэлтэй эсэх зэрэг мэдээллийг гаргаж өгөх боломжтой.

4.3 Октагон крипто бирж дээр мэдээлэл хадгалалт, нууцлал

Октагон крипто бирж нь дараах программыг ашиглаж нууцлал аюулгүй байдлыг хангаж ажилладаг. Үүнд:

1. **KYC :** Үйлчлүүлэгчээ танин мэдэх (KYC) нь хөрөнгө оруулалтын салбарын хамгийн чухал стандарт бөгөөд үйлчлүүлэгчийнхээ хувийн мэдээллийг баталгаажуулах, үйлчлүүлэгчийнхээ хөрөнгө оруулалтын мэдлэг болон санхүүгийн мэдээллийг мэдэх боломж олгодог. Хэрэглэгч бүрд KYC хэрэгжүүлснээр хэн хэдэн төгрөгийн гүйлгээ хийж байгааг бүртгэж, улмаар мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжтой юм.

2. **ДАН систем :** “ДАН” танилт нэвтрэлтийн нэгдсэн систем нь цахим орчинд бүх төрлийн цахим үйлчилгээг авахад тухайн иргэнийг таньж баталгаажуулах боломжийг бүрдүүлэх бөгөөд хувийн хэвшил болон төрийн үйлчилгээний өөр хоорондоо харилцан хамааралгүй системүүдтэй нягт уялдаатай ажиллах боломжтой нэгдсэн платформ юм.

3. **Wallet Key Encrypted :** Крипто бирж дээр бүртгэлтэй байгаа хэрэглэгч бүрийн “WalleT Key” буюу кодолсон хэтэвчийг шифрлэж нууцалснаар аль хэрэглэгчийн түлхүүр гэдгийг мэдэх боломжгүй болох юм.

4. **Database Backup is Encrypted :** Бид өөрсдийн мэдээллийн санг тогтмол хугацаанд өөр тийш хуулбарлан зөөж хадгалдаг бөгөөд тэрхүү мэдээллээ шифрлэж өгснөөр мэдээллээ алдах эрсдэлтэй хэдий ч тухайн мэдээллийг тайлж унших боломжгүй.

5. **Amazon Firewall Rule :** “AWS Network Firewall” дүрмийн бүлэг нь сүлжээний урсгалыг шалгах, зохицуулах олон дахин ашиглах боломжтой шалгуур үзүүлэлт юм. Зөвхөн зөвшөөрсөн байршлуудаас хандах эрхтэй.

6. Amazon Audit Log : Сервер дээрх бүх үйлдлийг бүртгэж бичнэ.

7. Amazon S3 Encrypted Bucket : Amazon S3-ын анхдагч шифрлэлтийн тусламжтайгаар та “S3 Bucket” өгөгдмөл шифрлэлтийн горимыг тохируулж өгснөөр бүх шинэ обьектыг Bucket дотор хадгалах үед шифрлэгдсэн болно. Объектуудыг AWS Key Management Service (AWS KMS) (SSE-KMS)-д хадгалагдсан Amazon S3 удирддаг түлхүүрүүд (SSE-S3) эсвэл AWS KMS түлхүүрүүдээр сервер талын шифрлэлт ашиглан шифрлэдэг.

8. Hashicorp Vault : HashiCorp Vault нь байгууллагуудын мэдээлэлд суурилсан аюулгүй байдлын автоматжуулалт, үйлчилгээ болгон шифрлэлтийн тусламжтайгаар зөрчил, мэдээлэлд өртөх эрсдэлийг бууруулахад тусалдаг.

Amazon S3 Encrypted Bucket : Amazon S3-ын анхдагч шифрлэлтийн тусламжтайгаар та S3 Bucket өгөгдмөл шифрлэлтийн горимыг тохируулах боломжтой бөгөөд ингэснээр бүх шинэ обьектыг Bucket дотор хадгалах үед шифрлэгдсэн болно. Обьектуудыг AWS Key Management Service (AWS KMS) (SSE-KMS)-д хадгалагдсан Amazon S3 удирддаг түлхүүрүүд (SSE-S3) эсвэл AWS KMS түлхүүрүүдээр сервер талын шифрлэлт ашиглан шифрлэдэг.

Hashicorp Vault : “HashiCorp Vault” нь байгууллагуудын мэдээлэлд суурилсан аюулгүй байдлын автоматжуулалт, үйлчилгээ болгон шифрлэлтийн тусламжтайгаар зөрчил, мэдээлэлд өртөх эрсдэлийг бууруулахад тусалдаг.

4.4 Октагон крипто биржийн аюулгүй байдалд хийлгэсэн эрсдэлийн үнэлгээний дүгнэлт

Манай байгууллагын Эрсдэлийн Удирдлагын Бодлогын үндсэн зорилго нь “Поверэд Эй Ди Эм” ХХК-ийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсэд нийцүүлэн компанийн нийт үйл ажиллагааны хүрээнд үүсэж болзошгүй эрсдэлийг урьдчилан илрүүлэх, үнэлэх, удирдах замаар бизнесийн тасралтгүй байдал, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, харилцагчдын эрх ашгийг хамгаалахад оршино. Өнгөрсөн 2025 онд энэхүү бодлогыг байгууллагын бүх түвшинд хэрэгжүүлж, эрсдэлд суурилсан шийдвэр гаргалтыг бэхжүүлэхэд анхаарч ажилласан.

Эрсдэлийн Удирдлагын Бодлого нь компанийн үйл ажиллагааны үндсэн эрх зүйн баримт бичгүүдийн нэг бөгөөд стратеги төлөвлөлт, өдөр тутмын үйл ажиллагаа, дотоод хяналт, комплайнс болон мэдээллийн аюулгүй байдлын бодлоготой уялдан хэрэгждэг. Тайлант хугацаанд олон улсын сайн туршлага, стандартуудыг бариmтлан эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулж, дотоод хяналт, эрсдэлийн үнэлгээний үйл явцыг илүү системтэй болгох чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн.

Манай байгууллага эрсдэлийг үйл ажиллагаа, систем, санхүү, хууль эрх зүй, зах зээл, өрсөлдөөн болон гадаад орчны гэсэн үндсэн ангиллуудад хуваан дотоод болон гадаад эрсдэлийг тогтмол үнэлж, хяналт тавин ажилладаг. Үүний хүрээнд эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, бууруулах, хүлээн зөвшөөрөх түвшинг тодорхойлох, хяналт тавих гэсэн шаталсан аргачлалыг хэрэгжүүлж байна.

Октагон крипто биржийн хувьд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор олон улсын стандарт, технологийн шийдлүүдийг ашиглан дараах хяналт, хамгаалалтын механизмыг хэрэгжүүлж байна. Үүнд:

- **Олон улсын хориг арга хэмжээ (OFAC)-ний жагсаалтад** багтсан хаяг, этгээдүүдтэй холбоотой гүйлгээг автоматаар илрүүлж, урьдчилан сэргийлэх;

- Хакер халдлага, ransomware болон хууль бус үйл ажиллагаатай холбоотой байж болзошгүй хөрөнгийг илрүүлж, шаардлагатай мохиолдолд царцаах, хязгаарлах механизм хэрэгжүүлэх;

- Ethereum болон бусад Блокчэйн сүлжээн дэх хаягуудын эрсдэлийн үнэлгээг хийх, сэжигтэй гүйлгээг нэмэлт шалгалтад оруулах хяналтын процесс хэрэгжүүлэх.

Эдгээр арга хэмжээнүүд нь манай байгууллагын мэдээллийн аюулгүй байдал, санхүүгийн эрсдэлийг бууруулах, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (AML/CFT) шаардлагуудыг хангах, хэрэглэгчдийн итгэлийг хамгаалахад чиглэгдэж байна.

4.5 Технологийн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

“Поверэд Эй Ди Эм” ХХК нь 2025 онд технологийн болон байгууллагын нийт үйл ажиллагаанд учирч болзошгүй дотоод болон гадаад эрсдэлийг байгууллагын “Эрсдэлийн Удирдлагын Бодлого”-ын хүрээнд нэгдсэн байдлаар удирдан хэрэгжүүлж ажилласан. Энэхүү бодлогын үндсэн зорилго нь байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлстэй уялдуулан үйл ажиллагааны тасралтгүй байдал, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, бизнесийн хөрөнгө болон харилцагчдын эрх ашгийг хамгаалах замаар эрсдэлийг бууруулахад оршино.

2025 оны майлант хугацаанд эрсдэлийн удирдлагыг олон улсын сайн туршлага, стандартын дагуу хэрэгжүүлж, дотоод хяналт, комплайнс, мэдээллийн аюулгүй байдлын уялдаа холбоог бэхжүүлэхэд анхаарч ажилласан. Үүний үр дүнд байгууллагын нэр хүндийг хадгалах, харилцагчдыг санхүүгийн луйвар, залилангаас урьдчилан сэргийлэх, мөн олон нийтэд үнэн зөв мэдээлэл түгээх, санхүүгийн мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлд бодит ахиц гарсан.

Манай байгууллага эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг дараах үндсэн зарчмын дагуу хэрэгжүүлж байна. Үүнд:

- Эрсдэлийн удирдлагын тогтолцоог тодорхойлох, хэрэгжүүлэх;
- Эрсдэлийн удирдлагын бодлого, журам, дотоод хяналтыг тогтмол сайжруулах;
- Эрсдэлийг системтэйгээр тодорхойлох, үнэлэх, дүгнэх;
- Эрсдэлийн эсрэг арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх болон эрсдэлд суурилсан ажлын соёлыг байгууллагын хэмжээнд нэвтрүүлэх.

Эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, бууруулах үйл явцыг тасралтгүй хэрэгжүүлэх зорилгоор байгууллага нь эрсдэлийн үнэлгээний тусгай баримт бичиг, дотоод журмуудыг ашиглан үйл ажиллагаагаа зохион байгуулдаг. Ялангуяа технологийн үйл ажиллагааны хүрээнд ажилтнуудын хандалтын эрхийн удирдлага, ажил үүргийн хуваарилалт, системийн ашиглалтын хяналт зэрэг нь өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол хэрэгжиж, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж байна.

Эрсдэлийн хариу арга хэмжээ

Манай байгууллага эрсдэлийг илрүүлж, үнэлсний үндсэн дээр эрсдэлийг бууруулах, хүлээн зөвшөөрөх түвшинд хүргэх зорилгоор дараах шаталсан арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагыг тодорхойлох;
- Эрсдэлийн хариу арга хэмжээ авах эсэхийг шийдвэрлэх;
- Боломжит хариу арга хэмжээний хувилбаруудыг тодорхойлох, харьцуулах;
- Эрсдэлийн хариу арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлэх;
- Эрсдэл тус бүрийг хариуцах ажилтан, нэгжид хуваарилах, хяналт тавих.

Мөн эрсдэлийн удирдлагын хүрээнд дараах аргачлалыг ашиглан эрсдэлийг удирдан ажиллаж байна:

- Эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй үйл явцыг бууруулах, маслан зогсоох;
- Бизнесийн боломжийг ашиглах зорилгоор тодорхой эрсдэлийг хүлээн зөвшөөрөх;
- Эрсдэлийн эх үүсвэрийг арилгах буюу бууруулах;
- Эрсдэлийн магадлал болон үр дагаврыг өөрчлөх;
- Оролцогч талуудтай эрсдэлийг хамтран үнэлэх, хэлэлцэх; Эрсдэлийн талаарх мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргаж, бүртгэлжүүлэх.

Эрсдэлийн хариу арга хэмжээг хэрэгжүүлэхдээ дараах мэдээллийг тусгасан баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллаж байна. Үүнд:

- Сонгосон хариу арга хэмжээний үндэслэл, хүлээгдэж буй үр нөлөө;
- Эрсдэлийн хариуцагчийн үүрэг, хариуцлагын хүрээ;
- Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө;
- Шаардлагатай нөөц, болзошгүй нөхцөл байдлын үнэлгээ;
- Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (KPI);

- Тайлагнал, хяналт-шинжилгээний шаардлага;
- Хугацаа, хуваарийн төлөвлөлт

5.Комплайнс

Криптовалютын зах зээл нь өндөр өгөөжтэй боломжуудыг агуулдаг хэдий ч дотоод болон гадаад зах зээлийн хэлбэлзэл, хууль эрх зүйн орчны өөрчлөлт, технологийн эрсдэл зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан өндөр эрсдэлтэй, динамик орчинд тооцогддог. 2025 оны майлант хугацаанд энэхүү онцлогт нийцүүлэн Октагон крипто бирж нь комплайнсын тогтолцоог бэхжүүлэх, олон улсын болон дотоодын зохицуулалтын шаардлагыг хангах чиглэлд үйл ажиллагаагаа тасралтгүй хэрэгжүүлж ажилласан.

Манай байгууллага хэрэглэгчдийн хөрөнгийн аюулгүй байдал, системийн найдвартай ажиллагаанг хангах зорилгоор олон улсын сайн туршлага, стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, комплайнс, мэдээллийн аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын уялдаа холбоог бэхжүүлсэн. Байгууллагын бүх түвшинд комплайнсын бодлого, дотоод журам, хяналтын механизмуудыг хэрэгжүүлж, ажилтнуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгож, өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдүүлэн ажиллаж байна. Мөн технологийн аюулгүй байдал, системийн найдвартай ажиллагаанг хангах чиглэлээр тогтмол хөгжүүлэлт, сайжруулалтыг хийж, зах зээлийн өөрчлөлтөд уян хатан, тогтвортой хариу үйлдэл үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Түүнчлэн, байгууллагын хүний нөөцийн бодлогын хүрээнд ажилтнуудын комплайнс, мэдээллийн аюулгүй байдлын мэдлэгийг дээшлүүлэх сургалт, мэдээллийг тогтмол зохион байгуулж, холбогдох стандарт(МАБУТ болон бусад)-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Комплайнсын шаардлагын дагуу зохицуулах байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг тухай бүр хэрэгжүүлж, шаардлагатай майлан, баримт бичгийг цаг тухайд нь боловсруулан хүргүүлж байна.

Манай байгууллага комплайнсын хэрэгжилтийг хангах зорилгоор хөндлөнгийн аудитын байгууллагаар жил бүр хяналт, шалгалт хийлгэж, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, илэрсэн зөрчил, эрсдэлийг бууруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Эдгээр арга хэмжээ нь байгууллагын үйл ажиллагаанд ил тод, найдвартай, зохицуулалтын шаардлагад нийцсэн байдлаар

явуулах, цаашдын тогтвортой хөгжлийг хангах суурь нөхцөл болж байна.

(Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.15.6 дах хэсэгт зааснаар сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэлд оролцогч талуудын хүрээнд)

5.1 Сонирхлын зөрчилтэй хэлцэлд оролцогч тал

“Поверэд Эй Ди Эм” ХХК нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 03 тоот тогтоолын Хавсралт 01-ээр батлсан “Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх журам”-ыг 2025 онд үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлж ажилласан. Тус журам нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос батлсан Компанийн засаглалын кодекс болон компанийн дүрэмд нийцсэн бөгөөд компанийн засаглал, ил тод байдал, хяналтын тогтолцоог хангах үндсэн баримт бичиг болно.

Энэхүү журмын хүрээнд гуравдагч этгээдтэй хийх их хэмжээний хэлцэл, компанийн нэгдэл дэх болон нэгдмэл сонирхолтой этгээдүүдтэй хийх хэлцлийн зохицуулалт, сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх нөхцөл, шаардлагуудыг тодорхой тусган хэрэгжүүлж байна. Мөн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэлд хамаарах мэдээллийг тухай бүр бүртгэх, майлагнах, хяналт тавих дотоод тогтолцоог мөрдүүлэн ажиллаж байна.

2025 оны майлант хугацаанд компанийн зүгээс сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй бөгөөд холбогдох журмын хэрэгжилт тогтмол хяналт, дотоод аудитын хүрээнд шалгагдаж, шаардлагад нийцсэн гэж үзэж байна. Цаашид компанийн засаглалын ил тод байдлыг хадгалах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналтын тогтолцоог бэхжүүлэх чиглэлд дээрх журмыг үргэлжлүүлэн мөрдөж ажиллах болно.

(Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.15.7 дах хэсэгт зааснаар эрсдэлийн удирдлагын хэрэгжилт, дотоод аудитын ажлын тайлангийн хүрээнд дараах мэдээллийг оруулсан болно)

5.2 Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт

“Поверэд Эй Ди Эм” ХХК нь 2022 онд нэвтрүүлсэн Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын ISO/IEC 27001:2013 олон улсын стандартыг 2025 онд үргэлжлүүлэн мөрдөн хэрэгжүүлж, мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог тогтвортой хадгалан ажилласан. Тайлант хугацаанд тус стандартын хүрээнд байгууллагын дотоод болон гадаад орчинд мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжийг хангах чиглэлээр боломжит түвшинд сайжруулалт хийж хэрэгжүүлсэн.

Эрсдэлийн удирдлагын бодлого болон дотоод аудитын журмыг байгууллагын бүх түвшинд мөрдүүлж, системийн төлөвлөлт, хэрэгжилт, майлагнал болон үйл ажиллагааны шийдвэр гаргалтад суурь баримт бичиг болгон ашиглаж байна. Нийт ажилтнуудын оролцоог хангах зорилгоор эрсдэлийн удирдлагын тогтолцоог тогтмол танилцуулах, хэлэлцэх ажлыг зохион байгуулж, үйл ажиллагаа болон технологийн хэлтсүүдийн хүрээнд 7 хоног тутмын тогтмол хурлаар эрсдэлийн асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэн ажилласан.

5.3 Дотоодын аудитын ажлын тайлан

2025 оны дотоод аудитын үйл ажиллагааг байгууллагын дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн. Дотоод аудитын баг нь Технологи, Үйл ажиллагаа болон Удирдлагын үндсэн хэлтсүүдийг хамруулан эрсдэлд суурилсан шалгалтыг гүйцэтгэж, үйл ажиллагааны уялдаа холбоо, хяналтын механизмыг үнэлсэн.

Аудитын үйл ажиллагааны хүрээнд өмнөх онуудын аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, байгууллагын үйл ажиллагаа, технологийн процессууд нь холбогдох журам, стандартын дагуу хэрэгжиж байгааг баталгаажуулсан. Тайлант хугацаанд ноцтой зөрчил (“үл тохирол”) илрээгүй бөгөөд тодорхой тооны сайжруулах зөвлөмжийг гаргаж, холбогдох нэгжүүдэд хүргүүлэн хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч ажилласан.

Мэдээллийн аюулгүй байдлын ISO 27001 стандартын хүрээнд дотоод аудитын шалгалтыг хэрэгжүүлэхэд байгууллагын үйл ажиллагаа тогтвортой, хяналтын тогтолцоо хэвийн хэрэгжиж байгаа нь тогтоогдсон. Аудитын явцад илэрсэн зөвлөмжүүдийг үндэслэн 2025 онд мэдээллийн аюулгүй байдал, дотоод хяналтын үйл

явцыг сайжруулах арга хэмжээг өөрсдийн нөөц бололцоогоор хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Цаашид дотоод аудитын үйл ажиллагааг жил бүрийн төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, эрсдэлд суурилсан хяналт, үнэлгээг тогтмол хийж, байгууллагын үйл ажиллагааг олон улсын стандарт, зохицуулалтын шаардлагад нийцүүлэн сайжруулж ажиллах болно.

6.ДҮГНЭЛТ

Октагон крипто бирж нь 2025 онд дотоод болон олон улсын криптовалютын зах зээлийн шилжилтийн, идэвхгүй, харьцангуй сул нөхцөл байдлыг даван туулж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг ханган ажилласан. Тайлант хугацаанд зах зээлийн хэлбэлзэл, зохицуулалтын орчны өөрчлөлт зэрэг сорилтууд үргэлжилсэн хэдий ч байгууллага дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, технологийн дэд бүтцээ бэхжүүлэхэд төвлөрч, цаашдын өсөлтийн суурь нөхцөлийг бүрдүүлсэн.

2025 оны байдлаар олон улсын криптовалютын зах зээлд институционал оролцоо нэмэгдэх, технологийн шийдлүүд бодит хэрэглээнд нэвтрэх, зах зээлийн тогтвортой байдал аажмаар сайжрах хандлага ажиглагдаж байна. Үүнтэй уялдуулан Монгол Улсад виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн эрх зүйн орчин үе шаттайгаар боловсронгуй болж байгаа нь салбарын урт хугацааны хөгжлийг дэмжих эерэг нөхцөл бүрдүүлж байна.

Октагон крипто бирж нь энэхүү хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн технологийн дэд бүтэц, системийн найдвартай ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулж, олон улсын жишигт нийцсэн үйлчилгээ үзүүлэх зорилтыг хэрэгжүүлж байна. Тайлант хугацаанд хийгдсэн дотоод болон хөндлөнгийн аудитын үр дүнд тодорхойлсон сайжруулах шаардлагатай чиглэлүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлж, системийн тогтвортой байдал, хэрэглэгчдийн хөрөнгийн хамгаалалтыг бэхжүүлэх арга хэмжээг авч ажилласан.

Манай байгууллага виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хувьд холбогдох хууль, зохицуулалтын шаардлагыг мөрдөн хэрэгжүүлж, комплайнс, эрсдэлийн удирдлага, мэдээллийн аюулгүй байдлын

тогтолцоог байгууллагын бүх түвшинд хэрэгжүүлэн ажиллаж байна. Цаашид бид эрсдэлээ бодитоор үнэлэх, бууруулах арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлэхийн зэрэгцээ дотоод үйл ажиллагааны бодлого, журмыг сайжруулж, хэрэглэгчдэд ашуулгүй, найдвартай, ил тод үйлчилгээ үзүүлэхэд анхаарч ажиллах болно.

Октагон крипто бирж нь олон улсын зах зээлтэй уялдсан технологийг хөгжлийг эрэлхийлэх, технологийн интеграц, бүтээгдэхүүн үйлчилгээний өргөтгөл хийх замаар өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх, Монгол Улсын крипто зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжихэд хувь нэмрээ оруулах зорилготойгоор үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлж, тэлэх болно.